



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/04/НА/СТА-ТӨА

Цахим хуудас:

www.audit.mn

Чойбалсан хот

2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 70584203 Цахим хаяг: Bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 70584204 Цахим хаяг: Semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Нармандах

Утас: 70584207 Цахим хаяг: Narmandakhd@audit.gov.mn

Аудитор: Ч.Удвалноров

Утас: 7058-4207, Цахим хаяг: udvalnorovch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	7
2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	9
3.1 Байгууллагын үйл ажилагаа	9
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин.....	9
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	10
4. Аудитын тайлан	11
4.1 Ерөнхий зүйл	11
4.2 Дотоод хяналт	11
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
4.4 Материаллаг байдал	12
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	12
5.1 Шилэн дансны мэдээлэл.....	12
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	12
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
8. Аудитын илрүүлэлт.....	13
8.1 Залруулсан алдаа.....	13
8.2 Төлбөрийн акт	13
8.3 Албан шаардлага.....	13
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ДОА	Дорнод аймаг дахь Төрийн аудитын газар
НА	Нотлох аудит
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨА	Төрийн өмчит аж ахуйн нэгж
УТҮГ	Улсын төсөвт үйлдвэрийн газар

1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДП-ын II байр, Утас/Факс: 7058-4203

2022.03.15 № 263

танай _____ -ны № _____ -т

Г ДОРНОД АЙМАГ ДАХЬ ДОРНОД
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН
ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ
Э.УНДАРМАА ТАНАА

Г

Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Дорнод аймаг дахь Дорнод их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дорнод аймаг дахь Дорнод их сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ



011020184

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	904,677,350.97	508,576,161.65
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	32,456,148.75	1,165,859.70
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	32,456,148.75	1,165,859.70
3121	Төгрөг	32,386,449.20	1,103,201.98
31211	Төрийн сангийн харилцах	20,376,704.75	574,864.28
31212	Монгол банк дахь харилцах	1,599,760.70	195,424.95
31213	Арилжааны банк дахь харилцах	9,864,533.75	219,942.75
31215	Нэмэлт санхүүжилтийн харилцах	326,150.00	73,910.00
31216	Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк	219,300.00	39,060.00
3122	Гадаад валют	69,699.55	62,657.72
31222	Монгол банк дахь харилцах	37,188.80	13,861.65
31223	Арилжааны банк дахь харилцах	32,510.75	48,796.07
33	АВЛАГА	587,610,982.00	229,369,696.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	150,000.00	00.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	587,460,982.00	229,369,696.00
35	БАРАА МАТЕРИАЛ	284,610,220.22	278,040,605.95
351	Түүхий эд материал	119,099,024.44	117,764,357.32
35110	Тусгай зориулалттай материал	118,981,794.44	117,764,357.32
35130	Эм боох материал	117,230.00	00.00
354	Хангамжийн материал	136,391,195.78	134,236,248.63
35410	Бичиг хэргийн материал	545,900.00	539,743.00
35420	Аж ахуйн материал	128,626,875.64	127,403,554.64
35430	Сэлбэг хэрэгсэл	144,500.00	00.00
35450	Барилгын засварын материал	8,000.00	00.00
35460	Хүнсний материал	780,070.14	7,100.99
35470	Бусад хангамжийн материал	6,285,850.00	6,285,850.00
35600	Мал амьтад	29,120,000.00	26,040,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	3,871,231,564.00	3,719,109,749.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	3,871,231,564.00	3,719,109,749.15
392	Биет хөрөнгө	2,972,696,753.21	2,827,918,141.04
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,853,861,086.47	2,853,861,086.47
39202	Хуримтлагдсан элэгдэл	-218,728,094.64	-328,092,141.96
39203	Авто-тээврийн хэрэгсэл	84,000,000.00	84,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-84,000,000.00	-84,000,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	746,979,652.77	733,616,089.41
39206	Хуримтлагдсан элэгдэл	-601,972,166.49	-617,797,793.50
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	297,666,538.16	296,880,749.56
39208	Хуримтлагдсан элэгдэл	-286,637,925.48	-290,042,365.60
39214	Бусад үндсэн хөрөнгө	60,873,215.00	60,873,215.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-27,577,034.58	-30,067,880.34
39217	Ном	148,231,482.00	148,687,182.00
393	Биет бус хөрөнгө	898,534,810.79	891,191,608.11
39301	Програм хангамж	34,185,810.50	34,185,810.50
39302	Хуримтлагдсан элэгдэл	-5,175,999.71	-12,519,202.39
39303	Бусад биет бус хөрөнгө	869,525,000.00	869,525,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,775,908,914.97	4,227,685,910.80
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	213,711,820.24	189,991,540.34
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	213,711,820.24	189,991,540.34
413	Өглөг	213,711,820.24	189,991,540.34
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,757,207.45	60,991,540.34

4136	Бусад өглөг	211,954,612.79	129,000,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	211,954,612.79	129,000,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,562,197,094.73	4,037,694,370.46
51	Засгийн газрын хувь оролцоо	4,562,197,094.73	4,037,694,370.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,338,938,878.95	2,338,938,878.95
51101	Өмч: - төрийн	2,338,938,878.95	2,338,938,878.95
512	Хуримтлагдсан үр дүн	170,112,728.74	-354,389,995.53
51210	Өмнөх үеийн үр дүн	170,112,728.74	170,112,728.74
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-524,502,724.27
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,053,145,487.04	2,053,145,487.04
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,775,908,914.97	4,227,685,910.80

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	986,344,621.95	772,852,411.98
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	850,751,321.95	617,862,911.98
120	Нийтлэг татварын бус орлого	850,751,321.95	617,862,911.98
120002	Хүүгийн орлого	379,574.89	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	850,371,747.06	617,862,911.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	692,371,330.00	390,989,851.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	121,251,037.26	147,001,453.50
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,749,379.80	79,871,607.48
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,593,300.00	154,989,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	135,593,300.00	154,989,500.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,281,464,728.20	1,297,327,536.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,281,464,728.20	1,297,327,536.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,269,830,522.20	1,264,586,455.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	766,901,998.28	725,829,809.38
210101	Үндсэн цалин	766,901,998.28	725,829,809.38
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,053,798.00	81,623,402.53
210201	Тэтгэврийн даатгал	31,200,886.48	61,263,654.90
210202	Тэтгэмжийн даатгал	656,860.84	2,289,978.89
210204	Ажилгүйдлийн даатгал	2,627,443.00	5,162,791.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,568,607.68	12,906,977.74
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,478,111.29	86,047,381.85
210301	Гэрэл, цахилгаан	36,807,010.69	27,339,670.71
210302	Түлш, халаалт	37,147,995.60	37,830,926.14
210303	Цэвэр, бохир ус	5,523,105.00	20,876,785.00
2104	Хангамж, бараа материалын зардал	36,506,171.56	49,739,296.20
210401	Бичиг хэрэг	10,163,408.20	8,758,730.00
210402	Тээвэр, шатахуун	4,393,969.00	4,136,944.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,834,528.36	4,074,380.00
210404	Ном, хэвлэл	765,780.00	526,700.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,699,670.00	1,312,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	14,648,816.00	16,467,573.97
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	13,363,031.11

Дорнод их сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210408	Бараа материал акталсны зардал	00.00	1,099,437.12
2105	Нормативт зардал	27,963,583.83	16,871,621.37
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	465,300.00	261,192.00
210502	Хоол, хүнс	24,689,883.83	16,594,829.37
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,808,400.00	15,600.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,675,389.50	7,643,890.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	00.00	3,945,900.00
210604	Урсгал засвар	9,675,389.50	3,697,990.00
2107	Томилолт, зочны зардал	9,753,262.20	3,255,798.00
210701	Гадаад албан томилолт	1,639,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	7,226,320.00	2,391,600.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	887,942.20	864,198.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	35,854,698.59	48,738,196.07
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	15,496,896.20	17,501,245.70
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	145,200.00	900,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	215,000.00	217,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,474,285.00	1,800,000.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	826,139.31	267,222.51
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	17,664,178.08	27,229,827.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	262,643,508.95	244,837,059.85
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,911,725.00	67,748,191.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,915,810.00	16,189,554.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	224,815,973.95	160,899,314.85
211	ХҮҮ	6,529,500.00	14,173,881.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	6,529,500.00	14,173,881.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	6,529,500.00	14,173,881.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,104,706.00	18,567,200.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,104,706.00	18,567,200.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	2,100,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,055,000.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	8,737,728.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,049,706.00	7,729,472.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-295,120,106.25	-524,475,124.27
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	109,648,625.00	27,600.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	27,600.00
225002	Найдваргүй авлагын алдагдал	109,648,625.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-109,648,625.00	-27,600.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-404,768,731.25	-524,502,724.27

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,338,938,878.95	2,053,145,487.04	574,881,459.99	4,966,965,825.98
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,338,938,878.95	2,053,145,487.04	574,881,459.99	4,966,965,825.98
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0	0	0	0
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0	0	0	0
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
C07	Тайлант үеийн үр дүн	0	0	-404,768,731.25	-404,768,731.25
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,338,938,878.95	2,053,145,487.04	170,112,728.74	4,562,197,094.73
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,338,938,878.95	2,053,145,487.04	170,112,728.74	4,562,197,094.73
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	0	0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,338,938,878.95	2,053,145,487.04	170,112,728.74	4,562,197,094.73
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0	0	0	0
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0	0	0	0
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0	0	0	0
D08	Тайлант үеийн үр дүн	0	0	-524,502,724.27	-524,502,724.27
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,338,938,878.95	2,053,145,487.04	-354,389,995.53	4,037,694,370.46

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,067,421,667.95	1,217,173,697.98
11	ТАТВАРЫН ОРЛОГО	00.00	00.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	931,828,367.95	1,062,184,197.98
120	Нийтлэг татварын бус орлого	931,828,367.95	1,062,184,197.98
120002	Хүүгийн орлого	379,574.89	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	681,331,593.06	979,184,197.98
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	519,665,782.00	749,081,137.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	124,916,431.26	150,231,453.50
1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	36,749,379.80	79,871,607.48
120009	Бусад орлого	250,117,200.00	83,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	135,593,300.00	154,989,500.00
131006	Засгийн газрын тусгай сангаас санхүүжих	135,593,300.00	154,989,500.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,133,455,438.00	1,239,658,887.03

21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,133,455,438.00	1,239,658,887.03
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,121,318,732.00	1,207,457,841.03
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	723,508,050.06	760,173,273.32
210101	Үндсэн цалин	650,083,306.06	724,734,806.32
210102	Нэмэгдэл	68,739,959.00	4,362,698.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,684,785.00	31,075,769.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,053,798.00	62,008,677.14
210201	Тэтгэврийн даатгал	31,200,886.48	47,843,646.14
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	2,999,281.00
210204	Ажилгүйдлийн даатгал	3,284,303.84	4,883,046.00
210205	Эрүүл мэндийн даатгал	6,568,607.68	6,282,704.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	79,404,611.29	86,059,381.85
210301	Гэрэл, цахилгаан	27,820,199.69	29,865,980.71
210302	Түлш, халаалт	46,061,306.60	37,830,926.14
210303	Цэвэр, бохир ус	5,523,105.00	18,362,475.00
2104	Хангамж, бараа материалын зардал	34,328,995.26	29,804,293.00
210401	Бичиг хэрэг	7,071,059.80	10,654,166.00
210402	Тээвэр, шатахуун	4,931,909.00	4,064,644.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,704,528.36	3,976,810.00
210404	Ном, хэвлэл	3,801,062.10	249,030.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,603,073.00	1,534,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	12,217,363.00	9,325,643.00
2105	Нормативт зардал	25,241,701.50	10,280,485.40
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	587,307.00	429,100.00
210502	Хоол, хүнс	22,029,394.50	9,527,345.40
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,625,000.00	324,040.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,684,247.10	21,277,039.70
210601	Багаж, техник, хэрэгсэл	99,500.00	3,610,460.00
210602	Тавилга	1,377,000.00	00.00
210604	Урсгал засвар	16,207,747.10	17,666,579.70
2107	Томилолт, зочны зардал	9,715,643.50	6,417,350.00
210701	Гадаад албан томилолт	1,639,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	5,838,600.00	2,296,400.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,238,043.50	4,120,950.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	147,750,458.79	145,957,462.72
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	11,847,326.40	22,125,262.35
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	800,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	145,200.00	1,519,250.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,000.00	217,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	255,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,903,615.00	4,776,000.00
210807	Газрын төлбөр	52,000.00	00.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	826,139.31	267,222.51
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	132,664,178.08	116,229,827.86
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,631,226.50	85,479,877.90
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	27,042,246.50	72,365,471.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,588,980.00	13,114,406.90
211	ХҮҮ	7,000,500.00	14,500,506.00
2112	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	7,000,500.00	14,500,506.00
211201	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр	7,000,500.00	14,500,506.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,136,206.00	17,700,540.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,136,206.00	17,700,540.00

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	2,700,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,086,500.00	00.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	00.00	8,737,728.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,049,706.00	6,262,812.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	-66,033,770.05	-22,485,189.05
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	8,805,100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	8,805,100.00
2200	Дотоод эх үүсвэрээр	00.00	8,805,100.00
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/	00.00	8,805,100.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	-8,805,100.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-66,033,770.05	-31,290,289.05
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	98,489,918.80	32,456,148.75
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	32,456,148.75	1,165,859.70

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Нийт орлого	төгрөг	1,067,421,668	1,183,984,982	1,217,173,698	-33,188,716	102.8
2	Нийт зардал	төгрөг	1,133,455,438	1,183,984,982	1,239,658,887	-55,673,905	104.7

3. Санхүүгийн тайлангийн тодруулга

3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Дорнод аймаг дахь Дорнод их сургуулийн үйл ажиллагааны чиглэл нь:

- Бакалаврын зэрэг олгох хөтөлбөр
- Магистрын зэрэг олгох хөтөлбөр
- Докторын зэрэг олгох хөтөлбөр зэрэг хувь хүний чадамжид суурилсан сургалтын үйл ажиллагаа эрхлэх, хөгжүүлэх, багшийн хөгжлийг дэмжих зорилготой дээд боловсролын байгууллага юм.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд УТҮГ гэсэн статустай байна. Өмч нь 100 хувь төрийн эзэмшилд байна.

3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Дорнод аймаг дахь Дорнод их сургууль нь 1991 онд байгуулагдсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах

бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Тус байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл 2010 онд 01 дугаар тушаалаар 11 хүний бүрэлдэхүүнтэй байгуулагдсан байна.

Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын 1.3-т “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;” гэж заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчилж, зардал гаргаагүй байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Дорнод аймаг дахь Дорнод их сургуулийн тайлан нь Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	32,456.10	1,165.90	-31,290.20
Авлага	587,610.90	229,369.70	-358,241.20
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	284,610.20	278,040.60	-6,569.60
Үндсэн хөрөнгө	3,871,231.60	3,719,109.70	-152,121.90
Нийт хөрөнгийн дүн	4,775,908.90	4,227,685.90	-548,223.00
Өр төлбөрийн дүн	213,711.80	189,991.50	-23,720.30
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,562,197.10	4,037,694.40	-524,502.70
Нийт өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,775,908.90	4,227,685.90	-548,223.00

Кассад бэлэн мөнгөний үлдэгдэлгүй байна.

Банкин дахь харилцах дансанд 1.2 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 278.0 сая төгрөг болж өмнөх оноос 6.6 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь бараа материалын зарцуулалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,081.6 сая төгрөг болж өмнөх оноос 13.7 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нь үндсэн хөрөнгө акталсантай холбоотой байна.

Богино хугацаат өр төлбөр данс нь 189.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Дорнод аймаг дахь Дорнод их сургууль нь байгууллагын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Дорнод аймаг дахь Дорнод их сургууль нь 2021 онд эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг ТУЗ-өөр батлуулж ажилласан байна.

4. Аудитын тайлан

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дорнод аймаг дахь Дорнод их сургууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, аудитор Ч.Удвалноров нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорнод аймаг дахь Дорнод их сургуулийн 2021 оны санхүүгийн тайланг Дорнод аймаг дахь төрийн аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Дотоод хяналт

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Захирлын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А/20 дугаар тушаалаар батлагдсан “Дорнод их сургуулийн дотоод хяналт, шинжилгээ үнэлгээний журам”-ыг дагаж мөрдөж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Дорнод их сургууль нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны байдлын тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 1,281.5 сая төгрөгөөс 2.0 хувиар буюу 25.6 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь тайлант онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллээс 351.9 сая төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорил нь бусад хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудит хийгдээгүй.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1.6 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 30.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 албан шаардлага өгснийг бүрэн хэрэгжүүлж, 587.5 сая төгрөгийн зөвлөмж өгсөн байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	1,687.9	2	1,687.9	-	-	-
Албан шаардлага	1	30,130.4	1	30,130.4	-	-	-
Зөвлөмж	3	587,460.9	3	587,460.9	-	-	-
Нийт дүн	6	619,279.2	6	619,279.2	-	-	-

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Захирлын албан тушаалын цалинг Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 1997 оны 88 дугаар тогтоолыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн тогтоосон нь уг тогтоолын хавсралтад заасан цалингийн жишигтэй нийцэхгүй байна.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 20.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 5.9 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 14.4 сая төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

8.2 Төлбөрийн акт

Түрээсийн орлого 14.8 сая төгрөгөөс төсөвт төвлөрүүлэх 40 хувь буюу 5.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь "Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна" гэж заасныг зөрчсөн байна.

8.3 Албан шаардлага

Захирлын албан тушаалын цалинг Засгийн газрын “Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай” 1997 оны 88 дугаар тогтоолыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, хүчингүй болсон 2018 оны “Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай” 264 дүгээр тогтоолыг үндэслэн олгож байна Энэ нь Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Аудитаар өгсөн акт, албан шаардлагын биелэлтийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Дорнод их сургууль	ДОА-2022/04/НА/СТА-ТӨА	Түрээсийн орлогын 14.8 сая төгрөгийн орлогоос улсын төсөвт төвлөрүүлэлт хийгээгүй.	Түрээсийн орлого 14.8 сая төгрөгөөс төсөвт төвлөрүүлэх 40 хувь буюу 5.9 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлэх	1	5,920.0			1	5,920.0						
2	Дорнод их сургууль	ДОА-2022/04/НА/СТА-ТӨА	Захирлын албан тушаалын цалинг Засгийн газрын "Төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" 1997 оны 88 дугаар тогтоолыг үндэслэн 1,200.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлсэн, хүчингүй болсон 2018 оны "Төрийн зарим албан тушаалын цалингийн сүлжээ, доод жишгийг шинэчлэн тогтоох тухай" 264 дүгээр тогтоолыг үндэслэн олгож байна Энэ нь Засгийн газрын 2019 оны "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 472 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.	Захирлын албан тушаалын цалинг тогтоохдоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль журам, эрх зүйн үндэслэлд нийцсэн санал хүргүүлж шийдвэрлүүлэх	1	14,400.0					1	14,400.0				
ДҮН					2	20,320.0	-	-	1	5,920.0	1	14,400.0	-	-		
Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал																
1	Дорнод их сургууль	ДОА-2022/04/НА/СТА-ТӨА	Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой	Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих мэдээллээс 15 мэдээллийн хугацааг хоцроож мэдээлсэн.	1	351,956.4	-	-	-	-	1	351,956.4	-	-		
ДҮН					1	351,956.4	-	-	-	-	1	351,956.4	-	-		
НИЙТ ДҮН					3	372,276.4			1	5,920.0	2	366,356.4				

